



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2019 оны 05 сарын 23 өдөр

Дугаар А/363

Арвайхээр


Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5 “а”, Ахмад настны тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.2, Сангийн сайдын 2018 оны 318 дугаар тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.6 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Орон нутгийн түүхэн бахархалт өв соёл, уламжлалт зан заншлыг залуу хойч үедээ түгээн дэлгэрүүлэх, сурталчлах зорилгоор ахмад зохиолч Г.Балдангийн “Ар Монголын голомт Зүүн хайрхан” номыг худалдан авахад 1500000 (нэг сая таван зуун мянга) төгрөгийг зарцуулсугай.

2. Дээрх арга хэмжээнд зарцуулах 1500000 (нэг сая таван зуун мянга) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгийн зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газар (Ц.Ганболд)-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Г. ГАНБОЛД

011100584